

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 2 сарын 23 өдрийн
52 дугаар тушаалын 3 дугаар
Хавсралт

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн
шинжээчийн багийн эрүүл мэндийн байгууллагад өгөх
ЗӨВЛӨМЖ
(Маягт №3)

ХЭНТИЙ АЙМАГ. “АЧ МАНАЛ” ӨЭМТ-д

2025 оны 04 сарын 03.

№	Магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн заалт	Шалгуур үзүүлэлтийн дугаар	Зөвлөмж	Хэрэгжүүлэх арга зам
Бүлэг 1. Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд				
Дэд бүлэг 1. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал.				
1.	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикоагулянт, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм/- ийн аюулгүй байдлыг хангадаг байх	4.1.	Өндөр эрсдэлт эмийн аюулгүй байдлын хяналтыг сайжруулах	• Өндөр эрсдэлт, ижил харагддаг, ижил дуудагддаг эмүүдийн жагсаалтыг дахин боловсруулж батлах • Ижил харагддаг, ижил дуудагддаг эмийн ялгалт таних тэмдгийг эм бүрд хийх • Ижил нэртэй, өөр тунтай эмийн нэршил, тун, савлагааг хяналтын хуудсаар нарийвчлан хянах • Хяналт үнэлгээний үр дүнг тооцон, авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн дүгнэлт бүхий тайлан бичих
2.	Үйлчлүүлэгчийн биеийн байдалд үнэлгээ хийж, унах эрсдлийг тоддорхойлж, гэмтэж бэртэхээс сэргийлдэг байх	5.2.	Унаж бэртэх эрсдлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга MNS 6211:2019 стандарт болон хавсралтуудыг хэрэгжүүлэх	• Үйлчлүүлэгчийн биеийн байдал, онош болон бусад нөхцөл байдалд үндэслэн унаж гэмтэх эрсдэлийг үнэлдэг шалгуур хуудас хөтлөх • Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчдэд тавих хяналтыг сайжруулах • Унах эрсдэлтэй үйлчлүүлэгчийг байгууллагын бүх ажилтнууд таньж мэддэг, сэргийлэх арга хэмжээ авч, тусламж үзүүлэх
Дэд бүлэг 2. Тусламж үйлчилгээний тасралтгүй байдал				
3.	Төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн байх	1.1	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 26.2.4, 26.2.5 дахь заалтыг хэрэгжүүлэх	• ӨЭМ Төв нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх журам боловсруулан, батлах • Журмын хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах ажлыг зохион байгуулах

Дэд бүлэг 3. Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчид өгөх мэдээлэл				
4.	Лавлагаа шатлалын тусламжид илгээсэн үйлчлүүлэгчийн тусламж, үйлчилгээнд хяналт тавьдаг байх	3.3	Лавлагаа шатлалын тусламжид илгээсэн үйлчлүүлэгчийн эргэн мэдээллийг сайжруулах	- Лавлагаа шатлалд илгээж тусламж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн биеийн байдал, эмчилгээ, үйлчилгээний талаарх эргэн мэдээллийг авч, бүртгэлтэй ажиллах, үр дүнг дүгнэж байх - Үргэлжлүүлэн хянаж, тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэхэд анхаарах
Дэд бүлэг 4. Үзлэг, оношлогоо, эмчилгээ				
А. Амбулаторийн тусламж, үйлчилгээ				
5.	Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалттай байх.	1.3	Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ оношлогооны түгээмэл үйлдлийн стандарт MNS 4621:2008 –ын дагуу амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг гарган батлах	- Амбулаториор хийх ажилбар үйлдлийн жагсаалтыг шинэчлэн батлах /үйлдэл, ажилбар бүрт тохирох стандартын хамт жагсаах/ - Эмнэлгийн мэргэжилтнүүдэд танилцуулж, баталгаажуулан, гарын авлагаар хангах. - Ажилбар үйлдлийг стандартын дагуу хийдэг, хянадаг, үр дүнг тооцож, шаардлагатай арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх. - Эмч мэргэжилтнүүд үйлдлийг хийх ур чадвар эзэмшсэн байдалд хяналт хийх.
Дэд бүлэг 5. Халдварын сэргийлэлт хяналт				
6.	Үйлчлүүлэгчид тарилга, арьс, салст цоолох ажилбар хийхдээ аюулгүй байдлыг хангаж ажиллах	2.1	ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын арвангуравдугаар хавсралтаар батлагдсан “Тарилгын аюулгүй байдлын заавар”-ыг уншиж судлах, мөрдөж ажиллах	- Үйлчлүүлэгчид тарилга болон арьс салст цоолох ямар нэгэн ажилбар хийхдээ ажилбар гүйцэтгэх тухайн орчинд тавигдах халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж ажиллах - Ажилбарын үед халдвараас сэргийлэх зарчмуудыг мөрдөж ажиллах - Арьс салст цоолох ажилбарын явцад тусгайлан бэлтгэсэн хяналтын хуудсаар үнэлгээ хийж, заавар, зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллах
7.	Эрүүл мэндийн ажилтныг жилд нэгээс доошгүй удаа халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд оруулдаг байх	3.1	ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн ажилтныг халдвараас сэргийлэх заавар”-ыг мөрдөж ажиллах	- Эрүүл мэндийн ажилтан бүрийг халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд Лавлагаа шатлалын эмнэлэг дээр жил бүр хамруулж ажиллах - Эрүүл мэндийн ажилтан бүрийг метициллин тэсвэртэй стафилококк ауриус илрүүлэх шинжилгээнд хамруулах - Ажилчдын эрүүл мэндийн асуудлыг хариуцсан эмчийг тушаалаар хавсран ажиллуулах - Ажилчдын эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, дархлаажуулалтын байдалд ХСХ багаас тавих хяналтыг сайжруулах
8.	Шинэ ажилтанг урьдчилан үзлэг	3.2	ЭМС-ийн 2029 оны А\537 дугаар тушаалын	Шинээр ажилд орж буй ЭМА-г Маягт-1-ийн дагуу ЭМ-ийн үзлэг шинжилгээ, дархлаажуулалтад оруулж ЭМ-ийн

	шинжилгээнд хамруулсан байх		гуравдугаар хавсралтаар батлагдсан “ЭМА-г халдвараас сэргийлэх заавар”-ыг мөрдөж ажиллах	хуудсыг ажилтны хувийн хэрэгт хавсаргах - Гепатит BCD, ХДХВ, сүрьеэгийн халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах - Гепатит В, улаанбурхан, улаанууд, гахай хавдар зэрэг дархлаажуулалтад хамрагдсан мэдээллийг авах, хамрагдсан бол дархлаа тогтоцыг үзүүлэх - Салхин цэцэгээр өвдсөн эсэх мэдээллийг авч дархлаажуулалтын мэдээний санд хүн нэг бүрийн мэдээллийг оруулах - Шинэ ажилтны эрүүл мэндийн үзлэг шинжилгээний явцад ХСХ багаас тавих хяналтыг сайжруулах
9.	Багаж хэрэгслийн арчилгаа савалгаа хадгалалт зөв байх	4.5	ЭМС-ийн 2019 оны А\537 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, ариутгах” зааварыг уншиж судлан мөрдөж ажиллах	- Тарианы өрөө бусад ажилбарын өрөөнд байгаа ариун материалын пакетны гаднах тэмдэглэгээ, битүүмжлэл, хэрэглээ, хадгалалтад хяналтын хуудсаар хяналт тавьж, заавар, зөвлөгөө өгч, үр дүнг тооцож ажиллах - Мөн ариун материал хадгалж буй бикс, шкаф зэрэг хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах - Ариун материал хадгалах зориулалтын шүүгээг нэмэгдүүлэх - Ариутгал, халдваргүйжүүлэлтийн явц, хэрэгжилтэд ХСХ багаас тавих хяналтыг сайжруулах
10.	Халдварт өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт хийдэг байх	6.2	ӨЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5292:2017 стандартын холбогдох заалтуудыг судлан мөрдөж ажиллах	- Халдварын шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийг түр тусгаарлах өрөөг зохион байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж бэлэн байдлыг хангаж ажиллах - Хөтөч сувилагчийг Халдварын шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг түр тусгаарлах, ангилан ялгалт хийх мэдлэг, чадварт сургах - Түр тусгаарлах өрөөний бэлэн байдал, нөхцөл байдалд ХСХ-ын тавих хяналтыг сайжруулж ажиллах

Бүлэг 2. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлт.

Дэд бүлэг 1. Засаглал, удирдлага, манлайлал

11.	Судалгаа шинжилгээнд үндэслэсэн дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй, хэрэгжилтэнд явцын болон төгсгөлийн үнэлгээ хийсэн, үр дүнг тооцсон байх	3.1	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	- Эмнэлгийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт үнэлгээ хийх - Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эмнэлгийн удирдлагын багийн хурлаар хэлэлцэн, тэмдэглэл хөтлөх
-----	--	-----	--	--

				Стратеги төөлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлт, үр дүнг тооцсон дэлгэрэнгүй тайлан бичих
12.	Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хийгдэх хяналт, үнэлгээ хэвшсэн байх	5.1.	Монгол улсын засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах	- Дотоод хяналт шалгалт хийх графикын дагуу хяналтын хуудсаар хяналтыг тогтмол, ойр давтамжтай хийж, дүгнэн, хяналтын үр дүнг тооцох, тайлан бичих - Дотоод хяналт, үнэлгээний дүгнэлтийг удирдлагын багийн хурлаар хэлэлцэж, тэмдэглэл хөтлөж, асуудлыг шийдвэрлэх

Дэд бүлэг 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын удирдлага

13.	Төв нь тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд дотоод хяналт, үнэлгээг тогтмол хийдэг байх	2.1.	Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/A565 тушаалд заасан ЧАБ-ын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх	- Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалд заасан ЧАБ-ын албаны хэрэгжүүлэх чиг үүрэгт заасны дагуу тусламж үйлчилгээний чанарын хяналт, үнэлгээг тогтмол хийх - Тусламж үйлчилгээний хяналт үнэлгээ хийх чиглэл бүрээр хяналтын хуудас боловсруулж, хяналт үнэлгээ хийх - Хяналт үнэлгээний үр дүнг тооцож, сайжруулах арга хэмжээ авах
14.	Чанарыг тасралтгүй сайжруулах арга хэмжээ зохион байгуулдаг байх	2.3.	ЭТҮ-ний чанар сайжруулах арга хэрэгслийг бүрэн хэрэгжүүлэх	- ЭТҮ-ний чанарын сургалтыг зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах - ЭТҮ-ний чанар сайжруулах арга /мэдээлэл цуглуулах, аудит хяналт, фокус ярилцлага, шууд үзлэг, ажиглалт, чанарын бүлгэм, чанарын өдөрлөг, СОФЕ арга, Кайзан саналын систем, ажиглалтын тойм үзлэг/, хэрэгсэл /асуумж, судалгаа, хяналтын хуудас, өрнөл зураг, асуудлын мод, шалтгаан нөлөөллийн зураглал, паретагийн диаграмм/-ийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж, үр дүнг тооцох
15.	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалтай холбоотой сургалтыг эмнэлгийн нийт ажилтнуудад /эмнэлгийн болон эмнэлгийн бус ажилтнуудад/ тогтмол зохион байгуулдаг байх	4.4.	Аюулгүй байдлын сургалт зохион байгуулах	- Сургалтын удирдамж, хөтөлбөр боловсруулж батлах - Сургалт зохион байгуулах - Сургалтын үр дүнг тооцох /сургалтын өмнөх болон дараах сорил авч дүгнэх/ - Сургалтанд оролцогчдыг бүртгэж, гарын үсэг зуруулах - Сургалтын тайлан бичих

Дэд бүлэг 3. Хүний нөөцийн хөгжил

16.	Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийлгэж, арга хэмжээ авдаг байх	1.4.	Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлийн үнэлгээ хийлгэх	- Ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуйн нөхцөлд мэргэжлийн байгуулагаар үнэлгээ хийлгэх - Үнэлгээний мөрөөр арга хэмжээ авч, дүгнэлттэй ажиллах
-----	--	------	--	---

				Ажилчдын хөдөлмөрийн норм нормативын судалгаа хийж, ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авч, баримтжуулах
Дэд бүлэг 4. Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал				
17.	Зайнаас (телемедицина) эмнэлзүйн зөвлөгөө авдаг тогтолцоог бүрдүүлсэн байх	3.4	Өрхийн ЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5292:2017 стандартыг мөрдөж ажиллах	- Зайнаас эмнэлзүйн зөвлөгөө авах журмыг боловсруулж, батлах - Лавлагаа шатлалын ЭМБ-аас зайнаас оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан тохиолдол бүрийг бүртгэж ажиллах - Зайнаас эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэлээр сургалтад хамрагдсан эмч, ажилчдын бүртгэл судалгаатай ажиллах - Журмын хэрэгжилтэд ЭМТҮЧАБ-ын баг хяналт тавьж ажиллах
18.	Хөтлөгдөх анхан шатны баримт бичгийн хөтлөлт, үг, товчлол, тэмдэг, тэмдэглэгээг тодорхойлж, ашиглах заавар, зохицуулалт хийх	4.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллах	- ӨЭМТ-ийн бичиг баримтын хөтлөлтийг журамлаж, цэгцлэх, тодорхой журам боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах - Байгууллагын бичиг баримтын журмаар ажилчдад сургалт хийж, журмыг мөрдүүлж ажиллах - Журмын хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтын багаас тавих хяналтыг сайжруулах
Дэд бүлэг 5. Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ				
19.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн байршил зүй зохистой байх	3.5	ӨЭМТ-ийн бүтэц үйл ажиллагааны MNS5292:2017 стандартын холбогдох заалтуудыг судлан мөрдөж ажиллах	- Эмнэлгийн нэг тоног төхөөрөмжид ноогдох талбайн хэмжээг стандартад заасан хэмжээнд нийцүүлж ӨЭМТ-ийн Сэргээн засах өрөө, лаборатори, яаралтай тусламжийн өрөөг зохион байгуулж эмнэлгийн тоног төхөөрөмжийг байрлуулах - Эмнэлгийн тоног төхөөрөмжийн байршил, хэвийн ажиллагаанд ЭМТҮЧАБ-ын баг, дотоод хяналтын багаас тавих хяналтыг сайжруулах
Дэд бүлэг 6. Барилга инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа.				
20.	Даралтат сав, хийн баллоны аюулгүй ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байх	3.1	Дэд бүтэцийн хөгжлийн сайдын 2004 оны 38 дугаар тушаалаар батлагдсан Барилгын норм ба дүрэм БНБД 42-01-04 мөн Хийн аж ахуйн аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах	- Зөөврийн Хүчилтөрөгчийн баллоныг баталгаажуулж аюулгүй ажиллагааг мөрдөж ажиллах - Даралтад сав, хүчилтөрөгчийн хийн баллоны аюулгүй ажиллуулах зааврыг боловсруулж ЭМТ-ийн даргаар батлуулан мөрдөж ажиллах - Аюулгүй ажиллагааны зааварт: - Баллоныг хэрэглэхийн өмнө ба хэрэглэх явцад анхаарах зүйлс - Хий алдагдсан, үнэртсэн үед авах арга хэмжээ - Даралтат сав, баллоныг хүлээн авах, ажиллуулах хадгалах, тээвэрлэх үед анхаарах зүйлс

			MNS ГОСТ 5583 Техникийн болон эмнэлгийн зориулалттай хийн байдалтай хүчилтөрөгч Техникийн шаардлага-ыг мөрдөж ажиллах	Хориглох зүйлс зэргийг заавал тусгасан байх - Мөн даралтат сав, баллоны ажилласан бүртгэлийг заавал хөтлөж ажиллах - Даралтат сав, баллон ажиллуулах ажилтанг сургалтад хамруулах - Хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах
Бүлэг 3: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд				
I.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шалгуур үзүүлэлтүүд				
21.	Дархлаажулалт хийх нөхцөл шаардлагыг хангасан байх /нэмэлт/	3.1	ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр 11 дүгээр хавсралтын тушаалын дагуу Эрүүл мэндийн бүртгэлийн маягт зөв бүрэн хөтлөх	- Хүйтэн хэлхээний хэмийн хяналтыг “Fridge tag”-р хянах - Сар бүрийн 1-нд “Fridge tag”-ыг Компьютерт UB оролтоор холбож хэмийн хяналтыг 60 хоногоор уншуулж, хэвлэж аваад өөрсдөө хянах, хадгалах - ӨЭ 6а маяганд хүүхдийн вакцин хийлгэсэн цаг минут, шилжилт хөдөлгөөн, дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт бүртгэх
II.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, технологийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд.				
1.Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ				
22.	Жирэмсэн эмэгтэйг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд хамруулсан хувь өмнөх оноос нэмэгдсэн байх	2.1	ӨЭМ-н төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 15.3.1, 15.3.3 дэхь заалт, ЭМС-ын 2021 оны А/760 дугаар тушаал, ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын заалтыг хэрэгжүүлэх	- Жирэмсний эхний 3 сарын дотор хяналтанд орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 93% ба түүнээс дээш үзүүлэлтэнд хүргэх - Мэргэшсэн эх баригчийг ажиллуулах - Аймаг, нийслэл, улсын дундаж үзүүлэлттэй харьцуулан үнэлж дүгнэлт хийж, сайжруулах арга хэмжээ төлөвлөн ажиллах, хэрэгжилтэнд дүгнэлт хийх
23.	Төрсний дараа эх, нярайд тавих хяналтыг стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлдэг байх	3.1	ӨЭМ-н төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 15.3.1, 15.3.3 дэхь заалт, ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын заалтыг хэрэгжүүлэх	- Эх, нярайн гэрийн эргэлтийг амаржих газраас гарснаас хойш 72 цагийн дотор эргэх эргэлтийн хувийг нэмэгдүүлэх - Эх, нярайд тавих хяналтыг стандарт, удирдамжийн дагуу үзүүлэх - Эх, нярайн гэрийн эргэлтийн чанарт ЭМТҮЧАББ-аас хийх хяналт, үнэлгээг тогтмолжуулах, үр дүнг хэлэлцэн, сайжруулах арга хэмжээг авч ажиллах
2.Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ				
24.	Хүүхдийн өвчний цогц менежментийг хэрэгжүүлж, үр дүнг тооцсон байх	1.1	ЭМС-ын 2019 оны “Заавар батлах тухай” А/593 тушаалын	- ХӨЦМ-ийн сургалтанд эмч мэргэжилтнийг бүрэн хамруулах - ЭМС-н А/593 дугаар тушаалаар баталсан маягт ашиглах

			“ХӨЦМ-ийн хүснэгтэн товхимол” хавсралтыг хэрэгжүүлэх	0-5 хүртлэх насны хүүхдийн өсөлтийн зөв хэмжиж үнэлэн ӨЭ-3а,б маягтыг зөв хөтлөх - Хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцох
25.	Өсвөр насны хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг удирдамж зааврыг дагуу хийдэг байх	2.4	ЭМС-н 2017 оны “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” А/399 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	- Өсвөр үеийн хүүхдийн өвчлөл, эрсдлийн судалгаатай болох - Удирдамжийг мөрдөж ажиллах - Хэрэгжилтэнд хяналт хийж, үр дүнг тооцох

4. Халдварт бус өвчний тусламж үйлчилгээ

26.	Тусламж үйлчилгээний жагсаалтанд заасан халдварт бус өвчний үзлэг, оношлогоо, эмчилгээ, хяналтыг стандарт, удирдамж, зааврын дагуу хийдэг байх	1.2	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 6.10, 8.5, 11.1 дэх заалтыг хэрэгжүүлэх	- Оношилгоо, эмчилгээ, үйлдлийн стандарт, удирдамж, зааврын жагсаалт шинэчлэн гарган батлах, мөрдөлтөд хяналт үнэлгээ хийх, хариу арга хэмжээний үр дүнг тооцох - Ажилтан бүрийг оношилгоо эмчилгээний чиглэлээр ашиглаж буй стандарт заавруудаар хангах - Шаардлагатай стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврыг ашиглах боломжоор хангагдсан байх /Цахим, UP TO DATE олон улсын платформ, хавтас, номын сан, гарын авлага/ ашиглалтын хувийг нэмэгдүүлэх
-----	--	-----	--	--

7. Халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээ

27.	Хүн амд халдварт өвчний үеийн тусламж үйлчилгээг үзүүлэх	1.1	Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны MNS 5292:2017 стандартын 23.1 , 23.3 заалт, мөрдөж ажиллах	- Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн үйлчлүүлэгчийн оношлогоо эмчилгээтэй холбоотой эргэн мэдээллийг авч хяналтыг хийх - Тусламж үйлчилгээний төрөл бүрээр үзлэг оношлогоо эмчилгээ хяналтыг хийсэн мэдээ тайланг зөрүүгүй гаргах
-----	--	-----	--	---

8. Уламжлалт анагаах ухаан болон сэргээн засах тусламж үйлчилгээ

28.	Уламжлалт анагаах ухааны жагсаалтанд заасан төрлөөр тусламж үйлчилгээ үзүүлдэг байх.	1.2	“ӨЭМ-н төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 5292:2017 стандартын 7.11; 9.1.10 дэх заалт, ЭМС-ын 2019 оны А/378 дугаар тушаалын хавсралтын 4.2; 6 дахь заалт, ЭМС-ын 2022 оны А/55 дугаар тушаалыг хэрэгжүүлэх	- Холбогдох тушаалыг үндэслэн өөрийн эмнэлэгт үзүүлэх сэргээн засах, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний жагсаалтыг батлах - Жагсаалтын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх өрөөг тус тусад нь гаргаж, тоног төхөөрөмжийн нэр төрлийг нэмэгдүүлэх, - Чанарын үзүүлэлтийг батлан гаргаж хэмждэг, дүн шинжилгээ хийж ажиллах
-----	--	-----	---	--

9. Сувилахуйн тусламж үйлчилгээ				
29.	Сувилахуйн тусламж, үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцсон байх	1.4.	Сувилахуйн тусламж үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийж үр дүнг тооцсон байх	- Сувилахуйн тусламж үйлчилгээнд хяналт, үнэлгээ хийж, хяналтын хуудас ашигладаг болох - Сайн туршлага, муу мэдээний санг баримтжуулж, авсан арга хэмжээ, үр дүнг дүгнэх
30.	ӨЭМТ-н онцлогт тохирсон сувилахуйн тусламж үйлчилгээний оношийн жагсаалт гаргаж, түүний дагуу авах арга хэмжээг боловсруулан үр дүнг тооцон дүгнэсэн байх	2.2.	ЭМС-ын 2015 оны 495, 496, 497 –р тушаалууд болон MNS-4621:2008 стандартыг хэрэгжүүлэн ажиллах	- ӨЭМТ-д үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээний оношийн жагсаалт гаргах - Тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, технологийг үнэлэхэд хяналтын хуудас боловсруулж ашиглах - Хяналтын хуудсын үр дүнг тооцдог, авсан арга хэмжээ дүгнэлтийг танилцуулж гарсан зөрчил түүний мөрөөр ажил зохион байгуулах
31.	Үйлчилгээ үзүүлэгч /сувилагч, мэргэжилтний/-ийн аюулгүй байдлыг хангасан байх	2.3	Үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангах журам батлах	- Үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах журам боловсруулж ӨЭМТ-ийн дарга батлах - Журмын хэрэгжилтийг ханган хяналт тавьж ажиллах
7. Тусламж үйлчилгээний ажилбар, гардан үйлдлийг хийх				
32.	Тусламж үйлчилгээний жагсаалтанд заасан гардан үйлдлийг стандарт, удирдамж, эмнэлзүйн зааврын дагуу хийдэг байх	1.1	MNS 4621:2008 стандартад заасан гардан үйлдлийн гүйцэтгэлд хяналтын хуудсаар үнэлгээ хийж, дүгнэх	- ӨЭМ-н төвийн тусламж, үйлчилгээний жагсаалтад заасан ажилбар, гардан үйлдлийг эмнэлгийн мэргэжилтнүүд хийж хэвших - Гардан үйлдлийн хэрэгжилтийг хяналтын хуудсаар тогтмол хяналт үнэлгээ хийж, дүгнэлт өгч ажиллах
10. Яаралтай тусламж үйлчилгээ				
33.	Амилуулах тусламжийг үзүүлэх мэргэжлийн багийг зохион байгуулж, дадлагажуулдаг байх	3.1	Насанд хүрэгсэдийн амилуулах суурь тусламжийн эмнэлзүйн удирдамж 2011-ийг судлан хэрэгжүүлэх, ЭМС-ын 2018 оны А/489 дугаар тушаалыг хэрэгжүүлэх,	- Өөрийн онцлогт тохирсон яаралтай тусламжийн багийг томилох, сургалтын төлөвлөгөө батлан, хэрэгжүүлэх - Эмнэлгийн мэргэжилтнүүдийг амилуулах суурь тусламжийн сургалтад хамруулан, уг тусламжийг үзүүлэх ур чадварыг эзэмшүүлэх, үнэлгээ хийдэг байх
11. Эмийн менежмент ба зохистой хэрэглээ				
34.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, аюулгүй байдалд дотоодын хяналт хийдэг байх	2.1	ЭМС-ын 2022 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/346 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.4.4 заалтыг хэрэгжүүлэх	- Эм зүйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг ӨЭМТ-ийн дарга батлах - Батлагдсан үзүүлэлтийн дагуу үнэлгээ, дүн шинжилгээ хийдэг байх - Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, эмийн чанар аюулгүй байдалд дотоод хяналт үнэлгээг тогтмолжуулах

				- Дотоод хяналт хийсэн ажлын тайлан, дүгнэлттэй (тоо, хувь) байх - Хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авсан, үр дүнг тооцох
35.	Нянгийн тэсвэржилтээс сэргийлж антибиотикийн хэрэглээг багасгах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээ авсан байх	3.1	ЭМС-ын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/414 дугаар тушаалын хавсралтын чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	- Өөрийн ӨЭМТ-д хэрэглэж байгаа антибиотикийн судалгааг гаргах - Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний талаар эмч, ажилтнууд болон үйлчлүүлэгчдэд сургалт хийх - Сургалтын үр дүнг үнэлж, дүгнэлт хийж ажиллах
36.	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эм /антикоагулянт, инсулин, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм гэх мэт/-ийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлсэн байх	3.7	Эрүүл мэндийн сайдын 2015 оны “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай” А/68 тоот тушаалын 4.3.4, 4.5, 5.6.3 дах заалт, Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг ханган ажиллах	- Өндөр эрсдэлт, ижил харагдаж, дуудагддаг эмийн зохистой хэрэглээний журам, жагсаалтыг шинээр боловсруулан, баталж, эмч мэргэжилтнүүдэд сургалт хийх - Журмын хэрэгжилтэнд дотоодын хяналтыг үр дүнтэй хийх, сайжруулах ажлыг зохион байгуулах - Өндөр эрсдэлтэй, ижил дуудагддаг, ижил харагддаг эмүүдийн хаягжилт, хадгалалтын талаар эмнэлгийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгсэл байрлуулсан бүх хэсэгт зохион байгуулалтыг сайжруулах, хяналт тавьж ажиллах

Шинжээчдийн баг:

Ахлагч: Ц. Дариймаа

Гишүүд: М.Оюунчимэг

Ж.Эрдэнэцэцэг

Ч.Батнасан

Хянасан: С.Мөнхсүх /ТҮЧМИА-ны мэргэжилтэн/